

2021 ОНЫ 5-Р САРЫН 3-ААС ЭХЛЭЖ СУРГУУЛЬ БА СУРГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ (товч агуулга)

Боловсрол, залуучууд ба спортын яамнаас БНЧУ-ын Засгийн газрын хуралдаантай холбогдуулан дараахь зүйлийг мэдээлж байна:

Эрүүл мэндийн яамнаас **2021 оны 5-р сарын 3-ны өдрөөс эхлэн** сургууль ба сургуулийн барилга байгууламж дахь үйл ажиллагааг хязгаарлах тухай арга хэмжээнд **нэмэлт өөрчлөлт** оруулсан. Энэхүү онцгой арга хэмжээгээр нь одоогийн байдалтай харьцуулахад дараахь зүйлийг өөрчлөв:

о Суурь сургуульд

- 2-р үе шатны сурагчдад нь биечлэн сургуульд явахыг нь зөвшөөрөгдөнө, тэгэхдээ сондгой долоо хоногт ангиудын эхний хагас нь сургалтанд оролцохгүй нөхцлүүд баримтлагдана.
- тэгш долоо хоногт ангиудын нөгөө хагас нь сургалтанд оролцохгүй (сондгой тоотой ангиудыг жигдлэх болно).

о Олон жилийн сургалттай дунд сургууль ба консерваторид

- зургаан, найман жилийн сургалттай гимназийн доод түвшний сурагчид болон найман жилийн боловсролын хөтөлбөртэй консерваторийн эхний дөрвөн жилийн сурагчдад нь сургуульдаа биечлэн явахыг зөвшөөрөгдөнө, тэгэхдээ сондгой тоотой долоо хоногт ангиудын эхний хагас нь сургуульд явахгүй бөгөөд тэгш долоо хоногт ангиудын хоёрдугаар хагас нь сургуульд явахгүй, (тоотой ангиуд байвал тоогоор нь жигдлэх болно).

о Сургууль ба сургуулийн барилга байгууламжийн үйл ажиллагааны бусад нөхцлүүд

- **бүх** сургууль ба сургуулийн байранд **гадаа** спортоор хичээллэхийг шинээр зөвшөөрөгдөнө (гаднах орон зайд),
- энэ нь энэхүү онцгой арга хэмжээгээр сургуульд биечлэн явахыг нь зөвшөөрөгдсөн сурагчид ба оюутнуудад хамаарагдана,
- энэхүү онцгой арга хэмжээгээр нь спортын үйл ажиллагааны талаар хэлэхдээ *“онцгой арга хэмжээний нөхцөлд спортын үйл ажиллагаа зохион байгуулахыг”* зөвшөөрөгдөнө гэж заасан байдаг, Боловсрол, залуучууд ба спортын яамнаас одоогийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа онцгой байдлын арга хэмжээнүүд нь сургуулиудын спортын үйл ажиллагааг зохион байгуулахад хүчинтэй байна гэж заагдсан юм,
- амьсгалын замыг хамгаалахад зориулсан онцгой арга хэмжээнд нь онцгой тохиолдлыг зааж байна (өөрөөр хэлбэл амны хаалт эсвэл амьсгалын аппарат зүүхгүй тохиолдлууд нь) ямар боловсролын үйл ажиллагаанд тэдний шинж төрлөөс болж үүнийг зүүж болохгүй вэ гэдэг нь заагдсан (энэ нь биеийн тамирын хичээл болно гэх мэт болно),
- сургуулийн спортын үйл ажиллагааны үеэр ч гэсэн ангиудын нэгэн төрлийн байдлыг баримтлах,

- өөрөөр хэлбэл сургууль ба сургуулийн барилга байгууламж дахь спортын үйл ажиллагааны зохион байгуулалтыг тусгайлан зохицуулаагүй, сургууль ба сургуулийн барилга байгууламж дахь спортын үйл ажиллагааг сайн дурны сонирхогчдын спортын холбоонуудын дүрмээр зохицуулагдахгүй, тэдний үйл ажиллагаа нь жижиглэн худалдаа ба үйлчилгээний асуудлыг зохицуулах онцгой байдлын арга хэмжээнд заагдсан байдаг,

- тусгай арга хэмжээний одоогийн найруулганд заасны дагуу Чех Улсад цэцэрлэгийн дотуур болон гадаа талбайд спортын үйл ажиллагаа хязгаарлалтгүйгээр эрхлэхийг зөвшөөрсөн бөгөөд бас спортын үйл ажиллагаа нь сургалтын боловсролын хөтөлбөрийн гол байр суурь эзэлдэг дунд ба дээд мэргэжлийн боловсролтой сургуулиудад эсвэл магадлан итгэмжлэгдсэн боловсролтой эсвэл сургалтын хөтөлбөртэй сургуулиудад хамаарагдах болно (хэрэв эдгээр хүүхдүүд, сурагчид ба оюутнуудад бусад арга хэмжээний дагуу боловсролд биечлэн оролцохыг зөвшөөрсөн бол).

- **Үлдсэн арга хэмжээнд өөрчлөлт гараагүй болно.**

- **2021 оны 5-р сарын 3-ны өдрөөс эхлэн хүүхэд, сурагч, оюутан ба сурагчдыг сургуулийн болон сургуулийн байранд заавал өвчний эсрэг сорилтонд хамруулах тухай Эрүүл мэндийн яамны онцгой арга хэмжээнд нэмэлт, өөрчлөлт оруулна. Одоогийн байдалтай харьцуулахад энэ арга хэмжээнд нь дараахь зүйлүүд нэмэгдэж байна:**

о зургаа, найман жилийн гимназийн доод түвшний сурагчид болон консерваторийн найман жилийн боловсролын хөтөлбөрийн эхний дөрвөн жилийн сурагчид нь сургуульд биечлэн ирж хичээл хийх тохиолдолд заавал өвчний эсрэг сорилт гарах үүрэгтэй.

о суурь сургуулийн сурагчид, түүний дотор 2-р үе шатны сурагчдад зориулж энэ үүргийг аль хэдийн онцгой арга хэмжээгээр нь зохицуулагдана:

сурагчдад сорилт хийх журам нь сондгой ба тэгш долоо хоногийн сургалттай 1-р үе шатын сурагчдын сургуульд явах дүрэмтэй адил байдаг;

- 2021 оны 5-р сарын 3-ны өдрөөс эхлэн амны хаалтыг заавал зүүх дүрмийг дагаж мөрдөх журмын дагуу Эрүүл мэндийн яамны онцгой арга хэмжээнд нэмэлт өөрчлөлт оруулав.

Энэ арга хэмжээнд одоогийн байдлаар дараахь зүйлийг нэмж оруулав:

о зургаа, найман жилийн гимназийн доод түвшний сурагчид нь гимназийн боловсрол эзэмшиж байхдаа ба консерваторийн найман жилийн боловсролын хөтөлбөрийн эхний дөрвөн жилд сурч байгаа сурагчид нь, наснаас үл хамааран, **эмнэлгийн нүүрний маск эсвэл түүнтэй адилтгах хэрэгслийг хамгаалалтын хэрэгсэл болгон хэрэглэх ёстой** (15-аас дээш насны сурагчийн хувьд эдгээр сургуульд сурч байхдаа FFP2 амьсгалын аппаратгүй байж болно),

о суурь сургуулийн сурагчид, түүний дотор ерөнхий боловсролын 2 дугар үе шатны сурагчид, мөн дунд сургуулийн элсэлтийн шалгалтанд хамрагдах өргөдөл гаргагч / оролцогчдын адил ижил дүрмийг аль хэдийгээр онцгой дүрмийн арга хэмжээгээр зохицуулж байна.